



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/82-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ТАРИАТ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Р.ТҮМЭНБАЯР ТАНАА

2022.02.24 № 78
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 2 орон тоогоор илүү ажилласантай холбоотойгоор 11,963.5 мянган төгрөгийн цалин хөлсийг олгосон байна. Тус зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтан төсвийн байгууллагын ажиллагчдын орон тоо, цалин хөлсийг тогтоох", Монгол Улсын ЗГ-ын 2018 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 267 дугаар тогтоолын 4-т "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг ... 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16 ... байхаар тус тус тогтоосугай", Монгол Улсын ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар 1.2-т "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,928,531.10	78,292,402.20
35	БАРАА МАТЕРИАЛ	81,928,531.10	78,292,402.20
35400	Хангамжийн материал	81,928,531.10	78,292,402.20
35410	Бичиг хэргийн материал	2,086,891.00	2,500,291.00
35420	Аж ахуйн материал	34,472,790.10	40,721,611.20
35430	Сэлбэг хэрэгсэл	9,969,000.00	7,293,000.00
35450	Барилгын засварын материал	14,029,850.00	12,777,500.00
35470	Бусад хангамжийн материал	18,500,000.00	15,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,459,035,461.74	3,094,689,846.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,459,035,461.74	3,094,689,846.38
39200	Биет хөрөнгө	2,434,862,795.18	3,072,229,679.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	728,192,664.00	736,192,664.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-113,632,718.33	-132,972,211.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,628,733.00	287,628,733.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,115,566.22	-69,206,079.56
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	118,148,082.67	128,055,281.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,848,328.85	-66,398,607.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,783,279.00	31,078,279.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,744,292.58	-21,953,555.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,412,739,998.00	3,029,611,185.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-743,448,955.51	-849,965,908.35
39217	Ном	159,900.00	159,900.00
39300	Биет бус хөрөнгө	24,172,666.56	22,460,166.71
39301	Програм хангамж	7,615,000.00	5,215,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,648,333.44	-4,960,833.29
39303	Бусад биет бус хөрөнгө	22,206,000.00	22,206,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,540,963,992.84	3,172,982,248.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,991.12	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,991.12	0.00
41300	Өглөг	22,991.12	0.00
41360	Бусад өглөг	22,991.12	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	22,991.12	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,540,941,001.72	3,172,982,248.58
51	Засгийн газрын хувь оролцоо	2,540,941,001.72	3,172,982,248.58
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	374,736,782.32	374,736,782.32
51200	Хуримтлагдсан үр дүн	1,801,889,834.21	2,433,931,081.07
51210	Өмнөх үеийн үр дүн	1,725,996,183.06	1,801,889,834.21
51220	Тайлант үеийн үр дүн	75,893,651.15	632,041,246.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,314,385.19	364,314,385.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,540,963,992.84	3,172,982,248.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	757,174,547.00	1,293,628,427.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	251,055,124.00	789,511,187.00
120	Нийтлэг татварын бус орлого	251,055,124.00	789,511,187.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	251,055,124.00	740,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	310,000.00	740,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	250,745,124.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	788,771,187.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	506,119,423.00	504,117,240.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,281,223.00	31,599,040.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	29,166,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,281,223.00	2,432,740.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	485,838,200.00	472,518,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	485,838,200.00	472,518,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	681,280,895.85	660,787,180.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,280,895.85	660,787,180.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	664,101,401.80	646,997,828.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,119,800.00	266,638,699.53
210101	Үндсэн цалин	258,119,800.00	266,638,699.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,238,877.07	34,938,643.88
210201	Тэтгэврийн даатгал	21,914,077.07	24,410,457.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,476,435.47	2,639,736.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,065,000.00	2,116,035.00
210204	Ажилгүйдлийн даатгал	620,664.53	532,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,162,700.00	5,240,182.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,873,124.10	20,627,841.00
210301	Гэрэл, цахилгаан	3,699,175.10	5,327,841.00
210302	Түлш, халаалт	14,173,949.00	15,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,341,839.12	39,518,273.00
210401	Бичиг хэрэг	3,931,920.00	3,617,400.00
210402	Тээвэр, шатахуун	32,388,459.12	26,429,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,781,580.00	1,650,000.00
210404	Ном, хэвлэл	585,000.00	418,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,966,100.00	4,964,233.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	688,780.00	2,197,950.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,503,601.00	2,407,350.00
210604	Урсгал засвар	2,835,601.00	2,407,350.00
2107	Томилолт, зочны зардал	2,794,000.00	2,450,000.00
210702	Дотоод албан томилолт	2,794,000.00	2,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,977,993.90	43,523,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,698,373.90	42,218,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	343,186.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,246.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	386,500.00	

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	46,888.00	50,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	661,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,162,944.61	236,893,261.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,655,191.10	61,601,458.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,020,000.00	295,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	214,487,753.51	174,996,802.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,179,494.05	13,789,351.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,179,750.00	3,728,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,179,750.00	3,728,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,999,744.05	10,060,551.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,999,744.05	10,060,551.47
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	75,893,651.15	632,841,246.86
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	800,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	800,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	75,893,651.15	632,041,246.86

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,736,782.32	364,314,385.19	1,725,996,183.06	2,465,047,350.57
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	374,736,782.32	364,314,385.19	1,725,996,183.06	2,465,047,350.57
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	75,893,651.15	75,893,651.15
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,736,782.32	364,314,385.19	1,801,889,834.21	2,540,941,001.72
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	374,736,782.32	364,314,385.19	1,801,889,834.21	2,540,941,001.72
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	374,736,782.32	364,314,385.19	1,801,889,834.21	2,540,941,001.72
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	632,041,246.86	632,041,246.86
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	374,736,782.32	364,314,385.19	2,433,931,081.07	3,172,982,248.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	506,429,423.00	504,857,240.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	310,000.00	740,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	310,000.00	740,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	310,000.00	740,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	310,000.00	740,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	506,119,423.00	504,117,240.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,281,223.00	31,599,040.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	29,166,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,281,223.00	2,432,740.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	485,838,200.00	472,518,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	485,838,200.00	472,518,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	496,602,148.00	482,177,240.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	496,602,148.00	482,177,240.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,422,653.95	468,427,888.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,119,800.00	266,638,699.53
210101	Үндсэн цалин	258,119,800.00	266,638,699.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,215,885.95	34,961,635.00
210201	Тэтгэврийн даатгал	21,891,085.95	24,433,449.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,581,200.00	2,639,736.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,065,000.00	2,116,035.00
210204	Ажилгүйдлийн даатгал	516,200.00	532,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,162,400.00	5,240,182.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,500,000.00	20,827,841.00
210301	Гэрэл, цахилгаан	3,326,051.10	5,327,841.00
210302	Түлш, халаалт	14,173,948.90	15,300,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,662,240.00	32,834,753.00
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,813,500.00
210402	Тээвэр, шатахуун	23,390,240.00	18,830,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	1,650,000.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,672,000.00	7,014,543.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,000.00	1,126,000.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	
2107	Томилолт, зочны зардал	2,794,000.00	2,450,000.00
210702	Дотоод албан томилолт	2,794,000.00	2,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,619,318.00	44,014,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,200,698.00	41,809,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	343,186.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,246.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	386,500.00	

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	46,888.00	50,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	800,000.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,911,410.00	65,900,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,891,410.00	65,369,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,020,000.00	531,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,179,494.05	13,749,351.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,179,750.00	3,688,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,179,750.00	3,688,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,999,744.05	10,060,551.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,999,744.05	10,060,551.47
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,827,275.00	22,680,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,827,275.00	22,680,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,827,275.00	22,680,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,827,275.00	22,680,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,827,275.00	22,680,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-9,827,275.00	-22,680,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,212,352.00	
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,212,352.00	
250006	Бусад зардал	1,212,352.00	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,212,352.00	
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,212,352.00	
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	1,212,352.00	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	473,218,200.00	463,197,648.53	10,020,551.47	97.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	473,218,200.00	463,197,648.53	10,020,551.47	97.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,829,400.00	459,808,848.53	10,020,551.47	97.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,638,700.00	266,638,699.53	0.47	100.0
210101	Үндсэн цалин	266,638,700.00	266,638,699.53	0.47	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,996,300.00	34,961,635.00	1,034,665.00	97.1
210201	Тэтгэврийн даатгал	25,330,700.00	24,433,449.00	897,251.00	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,666,400.00	2,639,736.00	26,664.00	99.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,133,100.00	2,116,035.00	17,065.00	99.2
210204	Ажилгүйдлийн даатгал	533,300.00	532,233.00	1,067.00	99.8
210205	Эрүүл мэндийн даатгал	5,332,800.00	5,240,182.00	92,618.00	98.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,500,000.00	20,827,841.00	1,672,159.00	92.6
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	5,327,841.00	1,672,159.00	76.1
210302	Түлш, халаалт	15,300,000.00	15,300,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	0.00	100.0

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	58,780,400.00	52,016,673.00	6,763,727.00	88.5
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	3,600,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	20,592,000.00	18,326,130.00	2,265,870.00	89.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	400,000.00	400,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,512,400.00	27,014,543.00	4,497,857.00	85.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,026,000.00	1,026,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,450,000.00	550,000.00	81.7
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,450,000.00	550,000.00	81.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,202,800.00	22,202,800.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,998,000.00	19,998,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	900,000.00	900,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,911,200.00	59,911,200.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,700,000.00	56,700,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,211,200.00	3,211,200.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,388,800.00	3,388,800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,388,800.00	3,388,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,388,800.00	3,388,800.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	473,218,200.00	463,197,648.53	10,020,551.47	97.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	472,718,200.00	462,457,648.53	10,260,551.47	110.3
320001	Орон нутгийн төсвөөс	472,718,200.00	462,457,648.53	10,260,551.47	110.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	740,000.00	-240,000.00	1.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	740,000.00	-240,000.00	148.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	26	-1	104.0
620001	Удирдах ажилтан	10	10	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	13	-1	108.3
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,599,040.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,599,040.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,599,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	818,080.00
210401	Бичиг хэрэг	213,500.00
210402	Тээвэр, шатахуун	504,580.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,811,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,811,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,669,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,669,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,599,040.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,599,040.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29,166,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,432,740.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тариат сумын ЗДТГ нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах чиг үүрэг бүхий аймаг, сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй удирдлагаар хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжих”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 473.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 632.1 сая төгрөгөөр буюу 24.9 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Бараа материал	81.9	78.3	(3.6)	(4.4)
Үндсэн хөрөнгө	2,459.0	3,094.7	635.7	25.9
Нийт хөрөнгө	2,540.9	3,173.0	632.1	24.9
Өр төлбөр	0.02	-	(0.02)	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,540.9	3,173.0	632.1	24.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,540.9	3,173.0	632.1	24.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 4.4 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 81.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 57.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 61.3 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 78.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 25.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 2,459.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 22.7 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 788.8 сая төгрөг нийт 811.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө шилжүүлсэний гарз 0.8 сая төгрөг, тайлант хугацаанд байгуулсан 175.0 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр тус тус буурч, 3,094.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 632.1 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	485.8	472.5	(13.3)
Нэмэлт санхүүжилтийн орлого	20.3	31.6	11.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	250.7	788.8	538.1
Төсөв байгууллагын өөрийн орлого	0.3	0.7	0.4
Үйл ажиллагааны орлого	757.1	1,293.6	536.5
Цалин, шимтгэлийн зардал	290.3	301.5	11.2
Бусад бараа үйлчилгээний зардал	77.6	65.0	(12.5)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52.0	43.5	(8.5)
Бараа үйлчилгээний бусад зардал	244.2	236.9	(7.3)
Урсгал шилжүүлэг	17.2	13.8	(3.4)
Үйл ажиллагааны зардал	681.3	660.7	(20.5)
Хөрөнгө шилжүүлсэний гарз	-	0.8	0.8
Үйл ажиллагааны үр дүн	75.8	632.1	556.2

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 13.3 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Харин үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 214.6 хувиар өссөн нь Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудыг орлогод авч, бүртгэж тайлагнасантай холбоотой байна. Урсгал санхүүжилтээс 10.0 сая төгрөг хэмнэгдэж, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 461.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх нийт 55.4 сая төгрөгөөр бууруулж, 406.0 сая төгрөгөөр хянаж баталжээ. Харин төсвийн тодотголоор 67.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 473.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 473.2 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс

472.5 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0.7 сая төгрөг төвлөрүүлэн нийт 473.2 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 463.2 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 10.0 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтээр Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1.2 сая төгрөг, усны үнийн хөнгөлөлтөөр Ар-Ус Ундарга ХХК-иас 20.5 сая төгрөг, Аймгийн ЗДТГ-аас цэрэг татлагын шатахуун, урамшууллын зардалд 0.7 сая төгрөг, ковид цах тахалтай холбоотойгоор байгууллага, иргэдээс хандиваар 8.7 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын зардалд аймгийн ИТХ-аас 0.3 сая төгрөг, Хүүхэд гэр, залуучуудын хөгжлийн газраас 0.2 сая төгрөг нийт 31.6 сая төгрөгийг тус тус хүлээн авч бичиг хэргийн зардалд 0.2 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 0.5 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлийн зардалд 0.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 21.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8.7 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллага нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 595.9 сая төгрөгийн өртөг бүхий Хоргын тогоо чиглэлийн 6 км авто замын засварын ажил, аймгийн ОНХС-аас 119.0 сая төгрөгийн өртөгтэй хадлангийн иж бүрдэл тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэж тайлагнасан байна.

Ковид цар тахлын тархалтыг бууруулах ажлын хүрээнд иргэд, ААНБ-аас 8.7 сая төгрөгийн мөнгөн хандивыг хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 19 үндсэн зорилтын хүрээнд 102 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Сумын засаг даргаас 95.0 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 473.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 463.2 сая төгрөгийг зарцуулж, 97.9 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 0.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд
 - Батлагдсан төсөвт зардлаас 10.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.
 - Төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн өртөг бүхий хогны машин худалдан авсан байна. Энэ нь тус сум нь аялал жуулчлалын гол бүс нутаг учраас хог ихээр хуримтлагдаж, сумын нэн тэргүүний анхаарах асуудлын нэг болсонтой холбоотойгоор зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлын улмаас хийгдсэн худалдан авалт байна.
 - Байгууллагын бүтэц орон тоог 2 орон тоогоор нэмэгдүүлэн, шинэ албан тушаал бий болгон, цалинд 11.9 сая төгрөгийн олгосон нь ЗГ-ын 43 дугаар тогтоолыг зөрчсөн байна.
2. Суудлын автомашин ашиглалтын судалгаа: Тус байгууллага нь нийт 49.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 автомашинтай, шатахууны зардалд 9.3 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 6.4 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тариат сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 146 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 4.2 % буюу 7.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Төсвийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгийн өртөгтэй хог ачих зориулалт бүхий автомашин худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Дээрх зөрчилд тус сумын ЗДТГ-ын дарга болон засаг даргаас тайлбар ирүүлснийг үнэлж үзээд ЗГ-ын тогтоолыг зөрчсөн учир зөрчлөөс хасах боломжгүй гэсэн хариуг өгч байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, 113.8 сая төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгө бүртгэлтэй, 2.4 сая төгрөгийн сумын бусад төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа санхүүгийн программ бүртгэлтэй зэрэг зөрчлүүд илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авах, санхүүгийн программыг ашиглагч байгууллагад шилжүүлэх зэрэг 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.9 сая төгрөгийн алдааг залруулж, 12.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлангаас үр дүнгийн тайлан руу түлш халаалтын зардлыг хөөн шалгахад үр дүнгийн тайланд 4.9 сая төгрөгөөр илүү, тээвэр шатахууны зардлыг 4.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залруулав.

4.2 Албан шаардлага

- Тус байгууллага нь тайлант онд 2 орон тоогоор илүү ажилласантай холбоотойгоор 11.9 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтан төсвийн байгууллагын ажиллагчдын орон тоо, цалин хөлсийг тогтоох”, Монгол Улсын ЗГ-ын 2018 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоолын 4-т “Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг ... 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16 ... байхаар тус тус тогтоосугай”, Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 267, 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулалттай холбоотой 11 захирамжийн хууль эрх зүйн үндэслэлийг оновчтой, тодорхой тусгаагүй, хамааралгүй заалтыг оруулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Тариат сумын ЗДТГ	3	16.9	1	4.9	0	0	2	12.0	0	0
	Дүн	3	16.9	1	4.9	0	0	2	12.0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Тариат сумын ЗДТГ	3	27.0	0	0	0	0	2	27.0	1	0
	Дүн	3	27.0	0	0	0	0	2	27.0	1	0
	Нийт дүн	6	43.9	1	4.9	0	0	4	39.0	1	0